

СУРАЛЦАГЧИЙН ХӨГЖИЛ ТӨЛӨВШИЛД АНГИ УДИРДСАН БАГШ НӨЛӨӨЛӨХ НЬ

*Н. Нямдорж
Доктор (Ph. D.)*

*Шинжлэх ухаан, технологийн их сургууль
Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль*

nyataa89@gmail.com

*Х. Уранчимэг
Докторант*

*Төв аймгийн Батсүмбэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн
нийгмийн ажилтан*

uugiuranchimeg@gmail.com

Хураангуй: Монголын ирээдүй бол хүүхэд залуучууд юм. Хүний хөгжил гэр бүлээс эхэлдэг бөгөөд 3-6 насанд хүний суурь төлөвшлийн 60% нь бий болж төлөвшдөг. Тийм учраас судалгаа I-р хүүхдийн хөгжил төлөвшилд гэр бүлийн орчин, найз нөхөд, багш сурган хүмүүжүүлэгч нөлөөлдөг бол хичээлээс гадуурх үйл ажиллагаа нөлөөлөх нь маш бага байна. Иймээс судалгаа II, III, IV-г авснаар суралцагчид, багш сурган хүмүүжүүлэгч, хичээлээс гадуурх үйл ажиллагааны хүрээнд хийгдэж байгаа ажлуудын хоорондын уялдаа холбоог сайжруулах, сайн үр дүн түгээн дэлгэрүүлэх зорилгоор судалгаагаа хийсэн.

Түлхүүр үгс: Хичээлээс гадуурх үйл ажиллагаа, ангийн суралцагчид, багш

УДИРТГАЛ

Хүүхдийн хөгжил төлөвшилд анги удирдсан багшийн гүйцэтгэх үүрэг оролцоог судлах, улмаар хүүхдийн хүмүүжилд анги удирдсан багшийн оролцоог дээшлүүлэх зорилготой. Тийм учраас судалгаа I-р хүүхдийн хөгжил төлөвшилд гэр бүлийн орчин, найз нөхөд, багш сурган хүмүүжүүлэгч нөлөөлдөг бол хичээлээс гадуурх үйл ажиллагаа нөлөөлөх нь маш байга байна. Иймээс судалгаа II, III, IV-г авснаар суралцагчид, багш сурган хүмүүжүүлэгч, хичээлээс гадуурх үйл ажиллагааны хүрээнд хийгдэж байгаа ажлуудын хоорондын уялдаа холбоог сайжруулах, сайн үр дүн түгээн дэлгэрүүлэх зорилгоор судалгаагаа хийсэн.

ОНОЛ, АРГА ЗҮЙН ХЭСЭГ

Хүүхдийн хөгжил гэдэг нь олон хүчин зүйлээс хамаардаг нарийн, төвөгтэй үйл явц юм. Энэ нь үр ураг бүрэлдэн тогтохоос эхлэн хорвоод мэндэлснээс хойш тасралтгүй үргэлжилдэг. Хүүхэд бүрийн хөгжил давтагдашгүй өвөрмөц шинжтэй байдаг төдийгүй хүүхдийн хөгжлийн ерөнхий зүй тогтолд захирагддаг ажээ. Биологийн болон орчны хүчин зүйлсийн нөлөөгөөр хүүхдийн бие махбодь, оюун ухаан, зан үйлд гарч буй дэвшилтэт өөрчлөлтийг хөгжил гэдэг.⁸⁰

- Биологийн талаас тайлбарлавал: Бойжилт-төлжилт нь төрлөхөөс заяагдсан урьдчилан өгөгдсөн, дэмжин удамших төлөвлөгөөний дагуу явагддаг.
- Танин мэдэхүйн талаас тайлбарлавал: Хүүхэд хүрээлэн буй орчны талаарх мэдлэгийг танин мэдэхүйн тусламжтайгаар олж авдаг.

1. Нялх нас: 0-1 нас⁸¹
2. Балчир нас: 1-3 нас
3. Сургуулийн өмнөх нас: 3-6 нас
4. Сургуулийн бага нас: 7-12 нас
5. Өсвөр нас: 11-15 нас
6. Орь залуу нас: 15-18 нас

Өсвөр нас: хүүхэд өөрий “БИ” нээх хөгжлийн үе юм. Би бол давтагдашгүй хүн, би мэдэж байна, надад итга, намайг тайван байлгаач, намайг хэнч ойлгодоггүй гэх мэтээр эргэн тойрондоо хандаж, гэр бүл, хуримтлуулсан туршлага, шинэ мэдлэг чадварт тулгуурлан, өөрийн гэсэн шинэ итгэл үнэмшил, үнэт зүйлсийг бий болгодог. Хүүхэд наснаас насанд хүрэх шилжилтийн үед санаа сэтгэл тогтворнүйтэх, ааш зан нь хувирах зэрэг хямралын шинж тэмдэг илэрнэ. Эцэг эхээсээ зай барьж эхэлнэ. Биеийн болон бэлгийн хөгжлийн өөрчлөлт, эсрэг хүйснийхэндээ татагдах зэрэг шинэ мэдрэмждээ сэтгэл нь тавгүйтэж, ичиж эргэлзэнэ. Мөн гадаад үзэмждээ анхаарал тавих нь ихсэж, удаан хугацаагаар толины өмнө эргэлддэг болно. Тэд эцэг эхээсээ илүү найз нөхдийн дүрэм журмыг эрхэмлэнэ.

Орь залуу нас: сургалт мэргэжлийн үйл ажиллагаа зонхилж, орь залуу насныхаа бие биерүүгээ хандах хандлага зонхилно. Бие бялдар хөгжил, бэлгийн бойжилт үндсэндээ дуусч, биеийн өсөлт удааширч, булчингийн хүч ажиллах чадвар мэдэгдэхүйц нэмэгдэж, эд эрхтний хөгжил, төлөвшил тогтворжих шатандаа орно. Өөрийн сэтгэл хөдлөлийгөөрийн “би”-гийн байдал гэж ухамсарлах, өөрийгөө бусдаас ялгаатай, өвөрмөц хувь хүн

⁸⁰ Хүүхдийн тусламжийн утас 108, 2015 он

⁸¹ Хүүхдийн тусламжийн утас 108, 2015 он

гэсэн мэдрэмж бий болно. Зарим тохиолдолд ганцаардах мэдрэмж үүсч болно.

Жан Пиаже: Танин мэдэхүйн хөгжлийн үе шат⁸²

0-2 нас Сэрэл хөдөлгөөний үе шат: Хүүхдүүд бие, сэрэл мэдрэхүйн тусламжтайгаар ертөнцийг танин мэднэ. Энэ шатны төгсгөлд нялх хүүхэд оюуны болон биеийн хөдөлгөөний үйл ажиллагаагаар танин мэдэж эхэлсэн байдаг.

2-6 нас Сэтгэхүйн үйлийн өмнөх үе шат: хүүхдүүд нь дүрд тоглож, хоорондоо харилцдаг нь орлуулан төсөөлж сэтгэх чадвартай болсныг харуулдаг. Энэ насны хүүхдийн сэтгэхүй нь хязгаарлагдмал, хүүхэд зөвхөн өөрийн байр сууриас эгоцентр шинжтэй, тэр бүр логик сэтгэж чадахгүй, харин хүртэхүй, зөн совиндоо баримжаалан сэтгэдэг. Тэд бодит байдал ба уран зөгнөл хоёрыг ялгаж чаддаг болох шатандаа явж байдаг.

7-11 нас Сэтгэхүйн бодит үйлдлийн үе шат: хүүхэд тодорхой ойлголт, ухагдахууныг ашиглаж сэтгэж эхэлдэг. Тэд ертөнцийг илүү бодитой, шалтгаалтай ойлгож чаддаг болно. Тэд юмсыг ангилж, юмс тогтвортой шинжээ хадгалдаг хэмээн сэтгэж чаддаг болно.

Зигмунд Фройд: Сэтгэц бэлгийн хөгжлийн үе шат⁸³

1. 0-1нас Амны үе шат: Хүүхэд ам түүний орчмын сэрэл, таатай мэдрэмжүүдэд төвлөрдөг. Хөхөөр хооллох нь сэтгэл хангамж, таашаалын гол эх үүсвэр болдог.
2. 1-3 нас Хошногны үе шат. Анус /хошног/ нь мэдрэмж, сэрлийн гол цэг болдог. Хүүхдийг суултуурт бие засаж сургах нь энэ үе шатны гол зорилт юм. 3-6 нас Шодойн үе: Төвлөрдөг. Эдип болон Электрийн зөрчил нь энэ үеийн шатны нэг хэсэг юм.
3. 7-11 нас Далд үе шат: Бэлгийн хэрэгцээ нь хориг саадтай уярах ба таашаалыг төрөл бүрийн үйл ажиллагаанаас авдаг.

Эрик Эриксон: Сэтгэц нийгэмшихүйн онол⁸⁴

1. 0-1нас Итгэх ба үл итгэхийн зөрчил: Хүүхдийн хэрэгцээ нь хангагдаж, тэднийг анхаарч асрах юм бол дэлхий ертөнцөд итгэлтэй болог. Хэрэв үгүй бол тэд хорвоо дэлхийг хүйтэн, осолтой газар гэж ойлгосноор үл итгэх мэдрэмжтэй болдог.
2. 1-3 нас Тусгаар байдал ба ичих эргэлзэхийн зөрчил: Хүүхдүүд өөрөө хооллох, бие засах зэргээр бие даахыг оролдож эхэлнэ. Тэд өөрийн байр сууринаас ярьж өөрийгөө батлан харуулж болно. Хэрэв тэд тодорхой түвшинд бие даахад суралцаж чадахгүй бол өөрийн чадвартаа эргэлзэж ичих мэдрэмжтэй болдог.

⁸² Бага насны хүүхдийн хөгжил хамгаалал, 2017

⁸³ Монголын хүүхдийн хөгжил, судлалын асуудлууд, 2017

⁸⁴ Ш.Ичинхорлоо “Хүүхдийн хөгжил”, 2014

3. 3-6 нас Санаачлага ба буруугаа мэдрэхийн зөрчил: хүүхдүүд шинэ бүгдийг оролдож, шинэ зүйлсийг таньж мэдэж хорвоо дэлхий рүү ханцуй шамлан ордог. Хэрэв тэдэнд тавьж буй хориг, хязгаар нь хэт чанга байж, няцаагаад байвал өөрсдийг нь байнга хэрэгт оруулаад байгаа энэхүү дотоод сэдлээ буруутгах мэдрэмжтэй болно.
4. 7-10 нас Хөдөлмөрч ба дутуу дулимаг байдлын зөрчил: Хүүхдүүд шинэ шинэ чадварууд эзэмшиж, төрөл бүрийн зүйлийг хийж бүтээхийг оролдоно. Хэрэв тэд шинэ чадварууд эзэмшиж, бүтээлч байх тал дээр бүтэлгүйтвэл дутуу дулимаг байдлын мэдрэмжтэй болно.

Монголчуудын насны үечлэл, онцлог⁸⁵

1. Зулрай үе- хэвлий дахь 2 сар хүртлэх
2. Нярай үе- Хэвлий дахь 3 сартайгаас төрсний дараа 2 сар хүртлэх хугацаа
3. Нялх үе- 2сараас 1 нухаажууас
4. Балчир нас – 2-4 нас
5. Бага нас – 5-8 нас
6. Өсвөр нас – 9-12 нас
7. Өсөх, идэр нас – 13-16

Судлаач Л.Дашнямын ангилал⁸⁶

Нас	биежүүлэх	ухаажуулах	гаршуулах
Нялх балчир 0-4	Тоглоом	Сургаал	Сургаал тоглоом
Балчир нас 4-8	Тоглоом ажил	Тоглоом ажил	Сургаал тоглоом
Өсвөр өсөх идэр 9-16	Ажил хөдөлмөр	Сургалт ажил	Ажил сургалт

Хүүхдийн хөгжил гэдэг нь хүүхэд өсөж бойжих явцдаа тооны гэхээс илүүтэй чанарын хувьд хэрэхэн хувьсан өөрчлөгдөж байгаа талаарх судалгаа болно. ⁸⁷

Хүүхдийн хөгжил гэдэг нь бие, оюун ухаан, сэтгэц, мэдлэг, чадвар болон биеэ авч явах байдал, аливаа юмс үзэгдэлд хандах харьцаа хандлага нэг түвшингээс дараагийн дээд шат руу шилжих хөдөлгөөн, чанарын өөрчлөлт гарах үйл явц юм. ⁸⁸

⁸⁵ Бага насны хүүхдийн хөгжил хамгаалал, 2017

⁸⁶ Бага насны хүүхдийн хөгжил хамгаалал, 2017

⁸⁷ Бага насны хүүхдийн хөгжил хамгаалал, 2017

⁸⁸ Хүүхдийг хүмүүжүүлэх эерэг арга, 2017

Хүүхдийн төлөвшил гэдэг нь дээрх хөгжлийн үр дүн, амьдралын бүхий л үйл ажиллагаагаар олж авсан мэдлэг, чадвар дадал, туршлага, бие хүний хөгжлийн цар хүрээ, түвшин, ерөнхий соёл юм. Бие хүний төлөвшилд нөлөөлөх хүчин зүйлийг байгалийн болон нийгмийн гэж хуваана. Хүүхдэд байгалийн бүтээгдэхүүн болохын хувьд хүнээс төрж өсөн торниж, үр удмаа залгамжилж, байгалийн шалгарлыг туулсан дээд зэргийн хөгжилтэй уураг тархи, мэдрэлийн систем бүхий амьд бодгаль юм. Иймд хүүхдийн хөгжил, төлөвшилд удамшил зохих үүрэг гүйцэтгэх хэдий ч нөгөө талаар хүрээлэн байгаа байгаль болон нийгмийн орчин, сургалт, өөрийн идэвхитэй үйл ажиллагаа нөлөөлнө. Сурган хүмүүжүүлэх үүднээс авч үзвэл хүүхдэд төлөвших хүмүүжил, төлөвшил нь дараах элементүүдийн нэгдлээр тодорхойлогддог бөгөөд бид эдгээрийг ямагт нэгдмэл үйл ажиллагаагаар тогтмол хэрэгжүүлж, хэвшил болгох шаардлагатай байдаг.

- Оюун ухааны хөгжил төлөвшил: хүүхдэд шинжлэх ухааны цэгцтэй мэдлэг олгож, тэдний танин мэдэх хэрэгцээ сонирхолыг өрнүүлж, сэтгэн бодох авьяас чадварыг хөгжүүлж, ертөнцийг үзэх үзэл, илтгэл төлөвшүүлэх зорилго чиглэлтэй үйл явц, үр дүнгийн нэгдлийг оюун ухааны хөгжил хүмүүжил гэх бөгөөд энэ нь мэдэхүйн чадамжаар төлөвшинө.
- Хөдөлмөрийн төлөвшил: Хүүхдэд хөдөлмөрт үнэнч шудрага зөв хандах, зах зээлийн харилцааны чиг хандлага, хөдөлмөрийн соёлын ерөнхий мэдлэг, чадвар төлөвшүүлэхэд чиглэгдсэн сурган хүмүүжүүлэх үйл явц, үр дүнгийн нэгдлийг хөдөлмөрийн хүмүүжил гэх бөгөөд энэ нь бүтээхүйн чадамжаар тодорхойлогдоно.
- Ёс суртахуйны боловсрол, төлөвшил: Хүн хүнтэйгээ харьцах, хүн төрлөхтний ёс суртахууны үнэт чанарыг эзэмшүүлэх, төлөвшүүлэх, нийгмийн харилцааны бүхий л хүрээнд мөрдөх хэм хэмжээ, нормыг ухамсарлуулах, ёс суртахууны өндөр хариуцлагатай үйл ажиллагааг ёс суртахууны боловсрол хүмүүжил гэнэ. Энэ нь оршихуй, нийгэмшихүйн чадамжаар төлөвшигдөнө.
- Бие бялдарын хөгжил төлөвшил: Нийгмийн шаардлагын дагуу хүний бие махбодын зөв хөгжлийг хангах биеийн тамир, спортын мэдлэг эзэмшүүлэх зорилго чиглэл бүхий үйл явц, үр дүнг бие бялдарын хөгжил, хүмүүжил гэх ба бие бялдарын хүмүүжил нь бүтээхүй, оршихуйн чадамжаар тодорхойлогдоно.
- Гоо зүйн боловсрол төлөвшил: байгаль, урлаг, уран сайхан, хүрээлэн буй амьдралын гоо сайхныг тусган үнэлж, гоо сайхны мэдрэмж, таашаал, ухамсар чадвар, дадал төлөвших үйл явц, үр дүнг гоо зүйн


боловсрол гэнэ. Энэ төлөвшилд хөгжим, дүрслэх урлаг, технологийн хичээлийн цогц чадамжууд илүү нөлөө үзүүлнэ.

- Эрх зүйн боловсрол, төлөвшил: хүүхдэд хууль эрхийн ухамсар, соёл төлөвшүүлэх зорилго бүхий зохион байгуулалттай үйл явц, үр дүнг эрх зүйн боловсрол хүмүүжил гэнэ. Сургалтын явцад оршихуй, нийгэмшихүйн чадамжууд энд голлох үүрэгтэй.

СУДАЛГААНЫ ХЭСЭГ


СУДАЛГАА 1 НЭГТГЭЛ

Судалгааг 2023.02.27-2023.04.05-ны хооронд хийж, ЕБС, ПК-н 43 багш, 350 суралцагчдаас авсан.




Судалгаагаа ЕБС болон ПК-н ижил насны суралцагчдаас авсан.

Суралцагчдын хөгжил, төлөвшилд гэр бүлийн орчин, багш сурган хүмүүжүүлэгч ,найз нөхөд ихээр нөлөөлж байхад хүмүүжлийн ажил бага нөлөөлж байна.




СУДАЛГААНЫ НЭГТГЭЛ 2






Судалгаа 2н хүрээнд 175 суралцагчдаас судалгаа авсан бөгөөд дийлэнх нь 15, 16, 17 насны хүүхдүүд байна. Харин хүйсийн хувьд авч үзвэл 43% нь эмэгтэй, 57% нь эрэгтэй байна.



Судалгаанд оролцсон суралцагчдын 75н ПК суралцагчид бол 100н ЕБС суралцагчид байна.



Бусад:

- Дээрх бүгд
- Ямар нэгэн үйл ажиллагаа зохиож буй
- Ном уншлага

- Сургуулийн орчинг цэвэрлэх
- Намрын ажилд явах
- Мэргэжил сонголт
- Уралдаан тэмцээн, нийгмийн ажил
- Физикийн хичээл
- Оролцоод хөгжье хөтөлбөр
- Сургуулиас зохион байгуулж байгаа үйл ажиллагаанд оролцох
- Спорт тэмцээн уралдаан
- Уран жиргээ
- Мэргэжил сонголт
- Сагс, волейболын тэмцээн
- Биеийн эрүүл мэнд лекц гэх мэт чиглэлээр ангийн багш суралцагчид хөгжүүлдэг байна. Үүнээс харахад суралцагчдыг анги удирдсан багш бүхий л төрлөөр өргөн хүрээнд хөгжүүлдэг нь харагдаж байна.



Зарим зохион байгуулсан ажлаар:


- Сагс, волейболын тэмцээн
- СӨУЗ-н сургалтаар хөгждөг гэх мэт

Ангийн суралцагчдыг эв нэгдэлтэй байх, хүүхэд бүрийг хөгжүүлэхэд багш хүүхэд нэг бүртэй нь анхаарч ажилладаг нь эндээс харагдаж байна.

7. АУБ дараах чиглэлээр ажил зохион байгуулах:

- Бие бялдар хөгжүүлэх юм зохиох
- Амьдарлын тухай лекц
- Хүүхдүүдэд чиглэсэн ажил зохион байгуулах
- Мэргэжлийн талаарх сургалт
- Ангийн хүүхдүүдтэйгээ ярилцдаг байх
- Цэвэр бичигтэн
- Нийгэм
- Оюун ухааны тоглоом

- Хувь хүнийг хөгжүүлэх талаар
- Хичээлийн давтлага
- Харилцааны мэдлэгийн талаар
- Ажлын байран дах үйл ажиллагаа
- Хөгжөөнт тэмцээн
- Мэтгэлцээн
- Санхүүгийн талаар лекц
- Явган аялал
- АХА тэмцээн
- Хичээлийн цагаар хичээлээ заах
- Төгсөх анги учраас илүү дутуу юм хийлгүй хичээлээ хиймээр байна
- Сайн үйлсийн аянд нэгдэх
- Шинэ тоног төхөөрөмж дээр ажиллах
- Ангийн суралцагчдийн саналыг аваад үйл ажиллагаа зохион байгуулах гэх мэт.



АУБ нь ангийн ажил зохион байгуулахдаа суралцагчдаасаа санал авч, түүнийхээ дагуу ажил хийх нь үр дүнтэй байдаг гэсэн байна.

Ангийн ажил зохион байгуулж суралцагчдыг хөгжүүлэхийн тулд өөрсдийнхөн саналыг сонсож, ажил зохион байгуулах нь илүү үр дүнд хүрдэг гэж үзээд АУБ нар суралцагчдаасаа санал авч ажлаа зохион байгуулдаг.

9. АУБ-н нөлөө:

- Хүмүүжлийн талаар нөлөө үзүүлдэг
- Байнгийн үлгэр дуурайлал авдаг

- Хөгжихөд тусалж дэмждэг
- Хувийн зохион байгуулалтын нөлөө үзүүлдэг
- Зөвлөмж өгдөг
- Боловсролыг чухалчилдаг
- Цэвэр цэмцгэр байхад тусалдаг
- Сургаж хүмүүжүүлдэг
- Сайн суралцахад тусалдаг
- Манлайлахад тусалдаг
- Хичээл зааж өгдөг
- Заримдаа ялгаварлаж харьцдаг
- Хааяа л дэмждэг
- Өөрөөрөө үлгэрлэдэг
- Ямар ч нөлөө үзүүлдэггүй
- Тусалдаггүй зөнгөөр нь хаядаг
- Шударга байдалд суралцуулдаг
- АУБ-н хорт зуршлаас урьдчилан сэргийлэх
- Бүх зүйлд тусалж дэмжих
- Хааяа чөлөө авах гэхээр өгдөггүй
- Ангийн асуудлыг шийддэг гэх мэтээр нөлөөлдөг гэж тодорхойлсон байна.

10. Танай сургууль хүмүүжлийн ямар ажил зохион байгуулдаг вэ?

- Архи, тамхины талаарх сургалт
- Спорт тэмцээн
- Урлаг соёлын тэмцээн
- АХА
- ДОХ лекц
- Эрүүл мэндийн үзлэг
- Ахмад настанд туслах
- Бүх төрлийн лекц
- Уран жиргээ
- Е-спорт
- Ёс зүйн сургалт
- Үе тэнгийн дээрэлхэлт
- СӨУЗ – дээрэлхэлтийн талаарх сургалт
- Гэр бүлийн хүмүүжлийн талаар
- Орчны цэвэрлэгээ
- Шатар, даамны тэмцээн

- Суралцагчдын соёлын талаар
- Гэр бүлийн хүчирхийллийн талаар
- Долоо хоног бүрийн 4 дэхь өдөр сургалт, лекц ордог
- Нийгмийн ажил
- Төрөл төрлийн сургалт ордог
- Хандивт нэгддэг
- Ахмад настанд тусалдаг
- Харилцааны талаарх сургалт
- Сонгон, секц
- Гэр бүл төлөвлөлтийн талаар
- Урлагийн үзлэг гэх мэт гэх мэтээр ажлуудыг зохион байгуулдаг гэж тодорхойлсон байна.

Судалгаа III

Сургуулиас дараах төрлүүдээр уралдаан тэмцээнийг жил бүр зохион байгуулдаг. Үүнд:

Урлаг

- Урлагийн наадам
- Хүрэл тулга яруу найраг
- Уран жиргээ уран уншлага
- Мэргэжил бүхэн сайан шүлгийн уралдаан

Спорт

- Сагсан бөмбөгийн тэмцээн
- Волейболын тэмцээн
- Ширээний теннисийн тэмцээн
- Шатрын тэмцээн
- Даамны тэмцээн
- Намрын спартикад

Илтгэл

- Эрдэм шинжилгээний хурлын удирдамж
- Баянчандмань илтгэлийн уралдааны удирдамж
- Шилдэг илтгэл шалгаруулах уралдааны удирдамж


Баяр угтсан


- Өв соёлоо дээдлэн үндэсний хувцасаараа гоёцгооё
- Эмэгтэй хүн танд захидалын уралдаан
- Үндэсний бахархал өдөрлөг
- Шинэ жилийн үйл ажиллагаа

Хөгжил төлөвшил


- Зөв хүн болцгооо цуврал лекц
- Миний тасаг миний гэр уралдаан
- Танд тустай сэдэвт гарын доор материал ашиглан бүтээл хийх аян
- Халуун сэтгэл аян
- Шилдэг ээлжит хичээлийн төлөвлөгөө боловсруулах шилдэг арга зүйтэй багш
- Байгаль эх дэлхий сэдэвт эсээ бичлэг
- Шилдэг тасаг шалгаруулах уралдаан
- МНТ АХА тэмцээн
 - Монгол хэлний өглөөлөг
 - Олон номын уналт асуулт хариултын тэмцээн
 - Хүүхдийн хөдөлмөрийн эсрэг хамтдаа уралдаан
 - Сургуулийн дүрэм журмыг хэн сайн мэдэх вэ? тэмцээн
 - Цэргийн дууны тэмцээн
 - Сайхан бичигтэн монгол бичгийн уралдаан
 - Хуулиа дээлье уралдаан
 - Номын баяр
 - Оюунлаг гэр бүл тэмцээн
 - Амжилтын үндэс номноос сэдэвт аян гэх мэт зүйлийг зохион байгуулдаг.

Судалгаа IV





Судалгаа 4-н хүрээнд анги удирдсан багш нараас авсан бөгөөд дийлэнх нь 30-40 насны багш нар байсан. Харин хүйсийн хувьд авч үзэхэд 31н эмэгтэй байсан.



АУБ-н зүгээс суралцагчдын саналыг сонсож, ангийн ажлын төлөвлөгөөгөө боловсрулдаг гэсэн байна.

4. Ангийн ажлаар зохион байгуулдаг ажлууд:

- ✓ Хүүхдийн сурлагын хоцрогдолыг арилгах
- ✓ Хүмүүжилд анхаарах
- ✓ Зөрчил гаргахгүй байхаас урьдчилан сэргийлэх
- ✓ Ангийн хурал хийх
- ✓ Судалгаа авах
- ✓ Хөгжөөнт тоглоом тоглох
- ✓ Мэргэжилд нь дурлуулах ажлыг зохион байгуулдаг
- ✓ Ангихамт олны нэгдмэл байдлыг нэмэгдүүлэх
- ✓ Хөгжил, төлөвшилд чиглэсэн ажил зохион байгуулах
- ✓ Ангийн суралцагчидтайгаа хамт тухайн сарын төлөвлөгөөгөө гаргадаг
- ✓ Хорт зуршлаас сэргийлэх ажлыг хийдэг

- ✓ Өөрийгөө хэрхэн хөгжүүлэх талаар ярилцдаг гэх мэт ажлыг ангийн зохион байгуулдаг.
 - ✓ АУБ нь ангийн суралцагчдын саналыг сонсож ангийн ажлаа зохион байгуулдаг байна. Ингэснээр хүүхэд нэг бүртэй харьцаж, хүүхэд илүү их нээлттэй болж, төрөл бүрийн өргөн мэдлэгтэй болно.
5. Ангийн суралцагчдын дунд дараах ажлыг зохион байгуулахад суралцагчид хөгжиж, идэвхтэй болдог. Үүнд:
- Хөгжөөнт тоглоом
 - Суралцагчдад чиглэсэн лекц
 - Сургамжит зөвлөгөө
 - Чөлөөт ярилцлага хийх
 - Саналыг нь сонсох
 - Танин мэдэхүйн тэмцээн
 - Давтлага өгөх гэх мэт зүйлийг хийснээр суралцагчид хөгжиж, идэвхтэй болдог гэсэн байна.
6. АУБ-ийн ангитай ажиллахдаа тогтмол хийдэг ажлууд:
- ❖ Анги хамт олны эв нэгдлийг бэхжүүлэх
 - ❖ Хүнтэй харилцах харилцааны сургалт хийдэг
 - ❖ АХА
 - ❖ Монито зохиодог
 - ❖ Ангийн хамгийн хамгийн шалгаруулдаг
 - ❖ Бяцхан зөвлөгөө, зөвлөмж өгдөг
 - ❖ Салхинд гарч нэг нэгнээ ойлголцдог
 - ❖ Хоорондоо ярилцдаг
 - ❖ Хүмүүжлийн талаар зөвлөмж өгдөг гэх мэт ажлыг АУБ тогтмол хийдэг байна.

ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

1. Үндсэн хичээлээс гадна хүүхдүүдийг ангийн ажил, хичээлээс гадуурх ажил гэх мэт зүйлээр хөгжүүлэх ажил их хоцрогдолтой байгаа тул чанарт анхаарах
2. Анги удирдсан багш ангийн суралцагчдын дунд зохион байгуулж байгаа аливаа тэмцээн, уралдааг, лекц, зөвлөгөө зэрэг нь ангийн суралцагчдын хүмүүжилд ихээр нөлөөлж байна.

ДҮГНЭЛТ

Өнөө үед багш гэдэг бол өсвөр залуу үеийнхэнд амьдралд нь хэрэгтэй мэдлэг, чадвар олгох тэднийг бие хүн болгон хүмүүжүүлэх арга ухаан

олгох ажлыг шинжлэх ухааны үндэстэй хийх мэргэжлийн ур чадвартай хүн юм.

Хүүхдийн хөгжил төлөвшилд гэр бүл, найз нөхөд, багш их нөлөөлж байгаа бөгөөд ангийн ажил буюу хичээлээс гадуурх үйл ажиллагаа дутмаг байгаа нь судалгаа нэгээс харагдаж байна.

Харин судалгаа 2 буюу суралцагчдын зүгээс ангийн ажлаар зохион байгуулсан ажлаар хөгждөг, өөрийгөө нээн илрүүлдэг гэсэн бол судалгаа 3 буюу сургуулийн зүгээс зохион байгуулдаг уралдаан тэмцээн, үйл ажиллагаа нь мөн адил суралцагчдын саналтай ойролцоо байна. Судалгаа 4 нь багш нараас авсан бөгөөд багш нар суралцагчдынхаа санал дээр үндэслэн ангийн ажлынхаа төлөвлөгөөг боловсруулж, хүүхэд нэг бүртэйгээ тулж ажиллаж байна.

Үүнээс харахад ангийн ажлаар хүүхдийг богино хугацаанд авьяас чадварыг нээн хөгжүүлэх, өргөн хүрээний мэдлэг олгох, ур чадварт суралцуулах гээд олон талыг давуу талууд байна.

Мөн судалгааны явцад Анги удирдсан багш нар нь олон төрлийн судалгаа нь дээр үндэслэн хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх, мэргэжлийн ур чадварт суралцахад хүүхэд бүрийн онцлогт нь тохирсон арга, техникээр тусалж, дэмжин хамтран ажиллаж байгаа нь харагдсан.

САНАЛ

- Хүүхдийн хөгжил төлөвшилд гэр бүл, найз нөхөд, багш нар нөлөөлж байхад ангийн ажил ба хичээлээс гадуурх ажлын нөлөөлөл бага байна. Тиймээс ангийн ажил ба хичээлээс гадуурх ажлаар богино хугацаанд хүүхдийг хөгжүүлж, өргөн хүрээний мэдлэг олгох бүрэн боломжтой байгаа бөгөөд Анги удирдсан багш сайн туршлагыг түгээн дэлгэрүүлж, суртачлах хэрэгтэй юм байна.
- Багш хүн бол шавь нарынхаа “толь” нь болдог. Багш хүний хүмүүжлийн нэг зэвсэг нь үг байдаг бөгөөд суралцагчид лекц, хэлэлцүүлгээр илүү их мэдээлэл авч, өөрсдийнхөө хөгжил, төлөвшил, хүмүүжлийг олдог гэсэн байна.

НОМ ЗҮЙ

[1]. Хүүхдийн тусламжийн утас 108, 2015 он

[2]. Бага насны хүүхдийн хөгжил хамгаалал, 2017

[3]. Монголын хүүхдийн хөгжил, судлалын асуудлууд, 2017

[4]. Ш.Ичинхорлоо “Хүүхдийн хөгжил”, 2014

[5]. Хүүхдийг хүмүүжүүлэх эерэг арга, 2017